БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БУА-2022/140/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn

Булган хот

2022 он

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр
Утас: 70342580 Цахим хаяг: ankhbayard@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг: enhtsoodolj@audit.gov.mn

Аудитор: Б.Пүрэвсүрэн
Утас: 70353717 Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт ........ 2-3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл........ 4
3. Аудитын тайлан ........ 11
3.1 Ерөнхий зүйл ........ 11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт........ 12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 12
3.4 Материаллаг байдал ........ 13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........ 13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг........ 14
3.8 Аудитын гол асуудал ........ 15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт........ 16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал........ 16
4. Аудитын илрүүлэлт........ 16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........ 17

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ХАА | Хөдөө аж ахуй |

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2022.02.23 № 34

танай ______-ны №______ т

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА Н.БАТЖАРГАЛ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

D:/bichighereg/2022A4toot

006020666

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.АНХБАЯР

D:/bichighereg/2022A4toot

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **600017180.00** | **41441763.00** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 56097185.00 | 39841768.00 |
| **351** | **Түүхий эд материал** | 1012730.00 | 1055310.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | | |
| 35130 | Эм боох материал | 1012730.00 | 1012730.00 |
| **354** | **Хангамжийн материал** | | |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1160292.00 | 795000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 38318303.00 | 25791698.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1968350.00 | 2636000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1270292603.94** | **1224969981.87** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1270292603.94 | 1224969981.87 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1130135603.94 | 1084872981.87 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1181226864.46 | 1174100261.39 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (196128683.12) | (208506064.53) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 137530630.00 | 137530630.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (137530630.00) | (137530630.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 203462364.01 | 184700435.07 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (104025492.04) | (110997384.77) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 69772733.00 | 84207604.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (24122182.37) | (38631869.29) |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | | |
| 39217 | Ном | | |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 140157000.00 | 140097000.00 |
| **39301** | **Программ хангамж** | 300000.00 | 300000.00 |
| **39302** | **Хасагдуулга** | (185000.00) | (245000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 140042000.00 | 140042000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1330309783.94** | **1266411744.87** |
| | **НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН** | | **4853214,18** |
| | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | | **4853214,18** |
| **413** | **Өглөг** | | **4853214,18** |
| **4131** | **Ажиллагсадтай холбогдсон өглөг** | | **4853214,18** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1330309783.94** | **1261558530.69** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1330309929.90 | 1261558530.69 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 418151929.90 | 418151929.90 |
| 51101 | Өмч: - төрийн | 278109929.90 | 278109929.90 |
| 51106 | Эздийн өмчийн бусад хэсэг | 140042000.00 | 140042000.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 420998258,52 | 359373608,34 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 420998258,52 | 427239861,59 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | (67866253.25) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 491159595.52 | 484032992.45 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1330309783.94** | **1266411744.87** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **763171650.00** | **698555909.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **121257150.00** | **70544031.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 121257150.00 | 56014576.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 88199000.00 | 38559000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 33058150.00 | 17455576.00 |
| 120009+140020 | Бусад орлого | | 14529455,00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **640714500,00** | **628011878,00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 627793500,00 | 612061500,00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 627793500,00 | 612061500,00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс | 1200000,00 | |
| | Нэмэлт санхүүжилтийн орлого | 12921000,00 | 15950378,00 |
| 131103 | ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс | | 9450378,00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч | 12921000,00 | 6500000,00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **840189873,60** | **766422162,25** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **840189873,60** | **766422162,25** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 786451961,27 | 722253891,80 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 456848580,66 | 449539777,00 |
| 210101 | Үндсэн цалин | 350161259,16 | 344669860,96 |
| 210102 | Нэмэгдэл | 93795801,50 | 90842403,38 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 12891520,00 | 14027512,66 |
| 210104 | Урамшуулал | | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 57336832,01 | 59485817,23 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 43845199,38 | 41639317,28 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4024401,88 | 4626518,90 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2312094,23 | 3628096,32 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 370721,51 | 871989,82 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6784415,01 | 8719894,91 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 37615654,00 | 37884282,00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4897994,00 | 4574660,00 |
| 210302 | Түлш, халаалт | 25425320,00 | 28479192,00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 7292340,00 | 4830430,00 |
| 210304 | Байрны түрээс | | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 23460139,40 | 23442273,00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5171500,00 | 2974588,00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4189159,00 | 4810350,00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2428090,00 | 2464650,00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210404 | Ном хэвлэлийн зардал | 375000,00 | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 275000,00 | 410000,00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3769600,00 | 7875980,00 |
| **2105** | **Нормативт зардал** | 25941190,86 | 13341225,00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 867940,00 | 501450,00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5029360,00 | 4604200,00 |
| **210601** | **Багаж хэрэгсэл** | | 2771000,00 |
| 210604 | Урсгал засвар | 5029360,00 | 1833200,00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 1597600,00 | 1438000,00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 61851861,00 | 38017069,50,00 |
| **210801** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 59204181,00 | 36674778,50 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1188000,00 | |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 564250,00 | 635175,00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 158130,00 | 139600,00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 77000,00 | 66400,00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 361200,00 | 194600,00 |
| 210807 | Газрын төлбөр | 299100,00 | 306516,00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 116770743,34 | 94501248,07 |
| **210901** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | | 14529455,00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2157000,00 | |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 114613743,34 | 79971793,07 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 53737912,33 | 44168270,45 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 23872500,00 | 33484200,00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 22052500,00 | 31044200,00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1820000,00 | 2440000,00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 29865412,33 | 10684070,45 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 29865412,33 | 10684070,45 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(77018223.60)** | **(67866253.25)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | (77018223.60) | (67866253.25) |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 278109929.90 | 82536000.00 | 1113151642.73 | 1473797572.63 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | -5828206.16 | -5828206.16 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **278109929.90** | **82536000.00** | **1107323436.57** | **1467969366.47** |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | |
| Тайлант үеийн үр дүн | | | -572154895.03 | -432112895.03 |
| **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **418151929.90** | **491159595.52** | **420998258.52** | **1330309783.94** |
| **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **418151929.90** | **491159595.52** | **420998258.52** | **1330309783.94** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | 6241603.07 | **6241603.07** |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **418151929.90** | **491159595.52** | **427239861.59** | **1336551387.01** |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | -7126603.07 | | -7126603.07 |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | |
| Тайлант үеийн үр дүн | | | -67866253.25 | -67866253.25 |
| **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **418151929.90** | **484032992.45** | **359373608.34** | **1261558530.69** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **730613500.00** | **666570878.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **88699000.00** | **38559000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 88699000.00 | 38559000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 88199000.00 | 38559000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 88199000,00 | 38559000,00 |
| 120009+140020 | Бусад орлого | 500000,00 | |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **641914500,00** | **628011878,00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 627793500,00 | 612061500,00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс | 1200000,00 | |
| | **Нэмэлт санхүүжилтын орлого** | 641914500,00 | 628011878,00 |
| 131103 | ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс | | 9450378,00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч | 12921000,00 | 6500000,00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **724648930,00** | **661374938,00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **724648930,00** | **661374938,00** |

| | | | |
|---|---|---|---|
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **670811017,67** | **617206667,55** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 456848580,66 | 444371562,82 |
| 210101 | Үндсэн цалин | 350161259,16 | 339501646,78 |
| 210102 | Нэмэгдэл | 93795801,50 | 90842403,38 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 12891520,00 | 14027512,66 |
| 210104 | Урамшуулал | | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 57336832,01 | 59485817,23 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 43845199,38 | 41639317,28 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4024401,88 | 4626518,90 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2312094,23 | 3628096,32 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 370721,51 | 871989,82 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6784415,01 | 8719894,91 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 42942654,00 | 34872282,00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4897994,00 | 4574660,00 |
| 210302 | Түлш, халаалт | 30752320,00 | 25467192,00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 7292340,00 | 4830430,00 |
| 210304 | Байрны түрээс | | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 18107780,00 | 16980716,00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3964000,00 | 3185096,00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3712700,00 | 5328000,00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2428090,00 | 2464650,00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1044700,00 | 887700,00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6958290,00 | 5115270,00 |
| **2105** | **Нормативт зардал** | 23641780,00 | 12348120,00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1190000,00 | 733970,00 |
| 210502 | Хоол , хүнс | 18113220,00 | 10428800,00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 4338560,00 | 1185350,00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4960130,00 | 6286200,00 |
| **210601** | **Багаж, техник хэрэгсэл** | 4915130,00 | 4453000,00 |
| 210604 | Урсгал засвар | 45000,00 | 1833200,00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1597600,00 | 1438000,00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1597600,00 | 1438000,00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 62454661,00 | 41423969,50 |
| **210801** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 59586981,00 | 39770678,50 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1188000,00 | |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 564250,00 | 635175,00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 158130,00 | 139600,00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 77000,00 | 66400,00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 581200,00 | 505600,00 |
| 210807 | Газрын төлбөр | 299100,00 | 306516,00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2921000,00 | |

| | | | |
|---|---|---|---|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2921000,00 | |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **53837912,33** | **44168270,45** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 23972500,00 | 33484200,00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 22052500,00 | 31044200,00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1920000,00 | 2440000,00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 29865412,33 | 10684070,45 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 29865412,33 | 10684070,45 |
| | Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ | 5384570,00 | 6315940,00 |
| | Хөрөнгө оруулалтын мөнгөн зардлын дүн | 5384570,00 | 6315940,00 |
| | Хөрөнгийн зардал | 5384570,00 | 6315940,00 |
| | Дотоод эх үүсвэрээс | 5384570,00 | 6315940,00 |
| | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 5384570,00 | 6315940,00 |
| | Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ | (5384570,00) | (6315940.00) |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 580000.00 | (1120000.00) |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 639995.00 | 12199995.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 1219995.00 | 99995.00 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Тайлант оны** | |
|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 711035500.00 | 651740500.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 711035500.00 | 651740500.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 678941300.00 | 607842229.55 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 446528900.00 | 444371562.82 |
| 210101 | Үндсэн цалин | 335707600.00 | 339501646.78 |
| 210102 | Нэмэгдэл | 95938300.00 | 90842403.38 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 14883000.00 | 14027512.66 |
| 210104 | Урамшуулал | | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 62306400.00 | 59485817.23 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 43845600.00 | 41639317.28 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4615200.00 | 4626518.90 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3692400.00 | 3628096.32 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 922800.00 | 871989.82 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9230400.00 | 8719894.91 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 39631500.00 | 34872282.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4238800.00 | 4574660.00 |
| 210302 | Түлш, халаалт | 27084400.00 | 25467192.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 8308300.00 | 4830430.00 |
| 210304 | Байрны түрээс | | |

| | | | |
|---|---|---|---|
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 13423500.00 | 12780716.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1585800.00 | 1585096.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3532200.00 | 3528000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2299300.00 | 1664650.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 888000.00 | 887700.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5118200.00 | 5115270.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 38359300.00 | 12348120.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1200000,0 | 733970,00 |
| 210502 | Хоол, хүнс | 34804300,00 | 10428800,00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2355000,00 | 1185350,00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 14893400,00 | 12602140,00 |
| **210601** | **Багаж техник зардал** | 10857400,00 | 10768940,00 |
| 210604 | Урсгал засвар | 4036000,00 | 1833200,00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 150900,00 | 138000,00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 150900,00 | 138000,00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 63647400,00 | 31243591,50 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 61892800,00 | 29590300,50 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 640000,0 | 635175,00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 142600,00 | 139600,00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 66400,0 | 66400,0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 505600,00 | 505600,00 |
| 210807 | Газрын төлбөр | 400000,00 | 306516,00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | | |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 32094200,00 | 43898270,45 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 32094200,00 | 33214200,00 |
| 213208 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 31044200,00 | 31044200,00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 105000,00 | 2170000,00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 711035500,00 | 650620500,00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 612061500,00 | 612061500,00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 612061500,00 | 612061500,00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 98974000,00 | 38559000,00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 98974000,00 | 38559000,00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 639995.00 | 12199995.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 1219995.00 | 99995.00 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | 1.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 41.00 | 41.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 34.00 | 34.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 6.00 | 6.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **41.00** | **41.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 650007 | Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ) | 6 | 60 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | | |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **-** | **15950378,00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **-** | **15950378,00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | - | 15950378,00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | 4200000,00 |
| 210401 | Бичиг хэрэг | | 1600000,00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 1800000,00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | 800000,00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | | 1300000,00 |
| 210702 | Дотоод албан томилолт | | 1300000,00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | 10180378,00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | 270000,00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | 270000,00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 270000,00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | |
| | **Нэмэлт санхүүжилтын орлого** | | 15950378,00 |
| 131103 | ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс | | 9450378,00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч | | 6500000,00 |

# 3. Аудитын тайлан

## 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь “Бейкер Тилли Далайван аудит” ХХК-ийн аудитор Б.Пүрэвсүрэн гүйцэтгэж, эхний шатны хяналтыг ахлах аудитор, захирал Д.Мягмарсүрэн хэрэгжүүлж, 2 болон 3-р шатны хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, Орхон аймгийн төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, Нийгмийн халамжийн тухай хууль, тогтоомжийн биелэлтийг хангуулан, төрийн хууль, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, үйлчлүүлэгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах таатай нөхцөлийг бүрдүүлэх,төрийн үйлчилгээг иргэдэд чанартай, хүртээмжтэй, шуурхай хүргэх үйл ажиллагаа эрхэлдэг.

Тайлант онд “Халамжаас-хөдөлмөрт” гэсэн зорилго дэвшүүлж, хэрэгжилтийг хангах дараах зорилт дэвшүүлсэн байна.

- Хүнс, тэжээлийн дэмжлэг туслалцаа үйлчилгээнд хамрагдаж буй өрхийн хөдөлмөрийн насны иргэдийг төсөл, хөтөлбөрт хамруулах, ажилд зуучлах замаар ажлын байртай болгож, халамжаас гаргах.
- Ажил хөдөлмөр эрхлэх талаар сургалт нөлөөллийн ажил зохион байгуулах.
- Мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөмж зөвөлгөө өгөх
- Аймгийн хэмжээний хөдөлмөрийн зах зээлийн судалгаа хийх
- Судалгаанд үндэслэн ажилгүй иргэдийн мэдлэг чадвар, хүсэл сонирхлын дагуу ажлын байранд зуучлах

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагад дотоод чанарын баталгаажуулалт, статистик хариуцсан ахлах ажилтан ажилладаг хэдий ч тухайн ажилтан чиг үүргээ хэрэгжүүлснээр тодорхой үр дүн гарсан эсэх нь тодорхойгүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл

баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "дунд" үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 711,035.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 7,110.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 4,977.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 63,898.0 мянган төгрөгөөр буюу 4,8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлттэй гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 1219,9 | 99,9 | 1120,0 |
| Авлага | 2700,0 | 1500,0 | 1200,0 |
| Бараа материал | 56097,1 | 39841,7 | 16255,4 |
| Үндсэн хөрөнгө | 1270292,6 | 1224969,9 | 45322,7 |
| **Нийт хөрөнгө** | **1330309,7** | **1266411,7** | **63898,0** |
| Өр төлбөр | 0.0 | 4853,2 | 4853,0 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 418151,9 | 418151,9 | 0 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **1330309,7** | **1266411,7** | **63898,0** |

Бараа материалын данс 39841,7 мянган төгрөг болж 16255,4 мянган төгрөгөөр буурсан нь аудитын зөвлөмжийн дагуу үндсэн хөрөнгөд шилжүүлсэн, акталж устгасан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1720880,9 мянган төгрөг болж 11403,6 мянган төгрөгөөр буурсан нь Аймгийн ИТХ-ын шийдвэрийн дагуу хөрөнгө акталснаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1261558,5 мянган төгрөг болж 68751,2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Дахин үнэлгээний зөрүү данс акталсан барилга байгууламжийн дүнгээр 7126,6 мянган төгрөгөөр буурсан байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого өмнөх оноос 64615,7 мянган төгрөгөөр буюу 8,4 хувиар, нийт зардал өмнөх оноос 73767,7 мянган төгрөгөөр буюу 8,7хувиар тус тус буурсан байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 825,936.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 825,936.4 мянган төгрөгөөр тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Тус байгууллагаас хүргүүлсэн төсвийн төслийг 90,218.9 мянган төгрөгөөр бууруулан 735,717.5 мянган төгрөгөөр баталсан байна. Тайлант онд төсвийг 2 удаа өөрчлөлт хийж 24,682.0 мянган төгрөгөөр бууруулж, 711,035.5 мянган төгрөгөөр баталжээ. Цалин, бараа үйлчилгээний зардлыг бууруулж төсөвт өөрчлөлт хийсэн байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр 711,035.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, урсгал үйл ажиллагаанд 651,740. төгрөгийг зарцуулж. Тайлант онд байгууллага 41 орон тоогоор ажиллаж, ахмадын амралтанд 8 ажилтныг бусдаар гүйцэтгүүлэх гэрээгээр ажиллуулсан. 10,684.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 2,157.3 мянган төгрөг, нийгмийн даатгалын ажил олгогчын шимтгэл 2,820.5 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой зардал 4,759.2 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 642.7 мянган төгрөгийн зардлаас тус тус хэмнэсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн орлого 15,950.4 мянган төгрөг байна. Үүнээс өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгааны санхүүжилт 6,500.0 мянган төгрөг, аймгийн Засаг даргын нөөцөөс ахмадын амралтыг тусгаарлах байраар ашигласантай холбоотой зардлын санхүүжилт 9,180.4 төгрөг, “Ногоон офисс” уралдааны шагнал 270.0 төгрөг тус тус орсон.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудитын хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй хэдий ч санхүүгийн тайланд авлага, өглөг бүртгэгдсэн байна. Энэ Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь заалтын дагуу "төсвийг зохистой удирдаж өр авлага үүсгэхгүй байх" гэсэн заалтын дагуу авлага өглөг үүсгэхгүй байх, авлага найдваргүй болохыг тогтоон шийдвэрлүүлэх арга хэмжээ авч ажиллах. Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ өртгөө нөхсөн тэг үлдэгдэлтэй ашиглагдахгүй байгаа болон ашиглагдаж байгаа 74 нэр төрлийн хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь УСНББОУС үндсэн хөрөнгө 17-ийн 49 Дахин үнэлэгдсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээс материаллаг ялгаатай байвал цаашид дахин үнэлэх зайлшгүй шаардлагатай " гэсэн заалтын дагуу дахин үнэлгээ хийх шийдвэрийг гаргуулан дахин үнэлгээг хийлгэн санхүүгийн тайланд тусгаж байх. Мөн тэг үлдэгдэлтэй ашиглагдахгүй байгаа хөрөнгийг заавар журмын дагуу актлуулах саналыг гаргуулан акталж устгах.

### 3.9 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь шилэн дансны цахим хуудсанд тогтмол болон тухай бүр мэдээлэх 148 мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн мэдээлсэн, тайлагнасан мэдээгээ орж хянаж байгаад санамсаргүй байдлаар 1 мэдээ хугацаа хоцроосон мэдээлсэн байна, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна. Тийм учраас асуудлын бүртгэлд тусгаагүй мөн шилэн дансанд мэдээлэх мэдээллийн талаар талбар бүрээр зөвлөгөө өглөө.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн. Тайлант хугацаанд 1,500.0 мянган төгрөгийн авлага, 4,853.2 мянган төгрөгийн өглөгтэй гарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь заалтын дагуу "төсвийг зохистой удирдаж өр авлага үүсгэхгүй байх" гэсэн заалтын дагуу авлага өглөг үүсгэхгүй байх, авлага найдваргүй болохыг тогтоон шийдвэрлүүлэх арга

хэмжээ авч ажиллах хүрээнд шалгасан зүйлийн холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 1645,4 мянган төгрөгийн дүнтэй 5 зөвлөмжийн хэрэгжилтийг 100 хувьтай хангуулсан байна.

Хүснэгт . Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тоо | дүн | тоо | дүн | тоо | дүн | хувь |
| Акт | - | - | - | - | - | - | - |
| Албан шаардлага | - | - | - | - | - | - | - |
| Зөвлөмж | 5 | 1645,4 | 5 | 1645,4 | - | - | - |
| Нийт дүн | 5 | 1645,4 | 5 | 1645,4 | - | - | - |

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар нэмэлт санхүүжилтийн дансаар, орсон санхүүжилтээр гарсан зардал тухай бүрт нь тайлагнаагүй бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс дансанд тайлагнаж байна. Цаашид зардлыг Сангийн сайдын 2021 оны 190 тушаалаар батлагдсан “ Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар ” журмын дагуу бүртгэж тайлагнахад анхаарах шаардлагатай.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 6,353.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч, 2 зөвлөмж өгсөн.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад залруулсан алдаа байхгүй.

### 4.3 Албан шаардлага

Аудитын явцад албан шаардлагын алдаа байхгүй.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалдаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал***

*1.1.* *Илрүүлэлт:* Тайлант хугацаанд 1,500.0 мянган төгрөгийн авлага, 4,853.2 мянган төгрөгийн өглөгтэй гарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь заалтын дагуу "төсвийг зохистой удирдаж өр авлага үүсгэхгүй байх" гэсэн заалтын дагуу заалтыг зөрчсөн байна.

*1.2.* *Өгсөн зөвлөмж:* Авлага өглөг үүсгэхгүй байх, авлага найдваргүй болохыг тогтоон шийдвэрлүүлэх арга хэмжээ авч ажиллах.

***Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал***

*1.3.* *Илрүүлэлт: Дансны үлдэгдэл үндсэн хөрөнгө*

Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ өртгөө нөхсөн тэг үлдэгдэлтэй ашиглагдахгүй болон ашиглагдаж байгаа 74 нэр төрлийн хөрөнгө байна. Энэ нь УСНББОУС үндсэн хөрөнгө 17-ийн 49 Дахин үнэлэгдсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээс материаллаг ялгаатай байвал цаашид дахин үнэлэх зайлшгүй шаардлагатай " гэсэн заалтын дагуу  дахин үнэлгээ хийх шийдвэрийг гаргуулан дахин үнэлгээг хийлгэн санхүүгийн тайланд тусгаж байх. Мөн

*Өгсөн зөвлөмж*: Тэг үлдэгдэлтэй цаашид ашиглахгүй хөрөнгийг заавар журмын дагуу акталж устгах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар | 2 | 6353,2 | - | - | - | - | - | - | 2 | 6353,2 |
| Дүн | | 2 | 6353,2 | - | - | - | - | - | - | 2 | 6353,2 |


АУДИТЫН ТАЙЛАНГ

БЭЛТГЭСЭН:

"БЕЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ" ХХК-ИЙН ОРХОН АЙМАГ ДАХЬ САЛБАРЫН

АУДИТОР: Б.ПҮРЭВСҮРЭН

ХЯНАСАН:

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР,ЗАХИРАЛ : Д.МЯГМАРСҮРЭН

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

АУДИТЫН МЕНЕЖЕР: Ж.ЭНХЦООДОЛ

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

БУЛГАНАЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Д.АНХБАЯР